




2023

ЖИЛИЙН ТАЙЛАН



КОМПАНИЙН ТУХАЙ

“Багануур” ХК нь анх 1978 онд 200.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтай “Багануурын нүүрсний түр уурхай” нэртэйгээр гараагаа эхэлж, эдүгээ 45 дахь жилдээ ажиллаж байна.

Багануурын уурхай нь төвийн бүсийн эрчим хүчний станцууд болох ДЦС-4 ТӨХК-ийн 50%, ДЦС-3 ТӨХК-ийн, ДЦС-2 ТӨХК-ийн 100%, Дархан, Эрдэнэт ДЦС-ийг 10-30%, Багануур, Төв аймаг, Сэлэнгэ, Хөтөл тосгоны дулааны станц, уурын зуухнуудыг 100% эрчим хүчний нүүрсээр ханган ажиллаж байна. Багануурын уурхайн нүүрс олборлолтын жилийн хүчин чадал 4.0 сая. тн боловч өнөөдрийн байдлаар дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч жилд 4.6 сая.тн нүүрс олборлож төслийн хүчин чадлыг 15%-иар нэмэгдүүлэн Монгол Улсын эрчим хүчний нүүрсний хэрэглээний 47 хувь, төвийн бүсийн хэрэглэгчдийн 52 хувийг дангаараа хангаж байна.

Нүүрсний орд нь зүүн хойноос баруун урагш чиглэсэн суналтын дагуу уртаараа 12 км, өргөнөөрөө 4-5 км талбай эзэлж мульд маягаар тогтсон үндсэн 3 давхаргаас бүрдэнэ. Багануурын нүүрс нь эрчим хүчний зориулалттай Б2 маркийн нүүрсэнд хамаарна. Нүүрсний үнслэг нь 12-17%, чийглэг нь 28-33%, хүхрийн агуулга нь 0.4%, дулаан гаргах илчлэг нь 3200-3600 ккал/кг.

1978 онд баталсан тооцоогоор нүүрсний нөөц 599.0 сая.тн 1988 онд нарийвчилсан хайгуул хийж ордын нөөцийг 708.2 сая.тн болгосон. 2014-2015 онд Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар Багануурын нүүрсний ордын гүйцээх хайгуулын ажил хийгдэж балансын нөөцийг 280.0 сая.тн-оор нэмэгдүүлж Олон улсын JORC стандартаар үнэлэгдсэн нийт 812.0 сая.тн баталгаат нүүрсний нөөцтэй болсон.

Багануурын нүүрс нь физик, химийн шинж чанараараа эрчим хүчний зориулалтаар ашиглагдахаас гадна цаашдаа дахин боловсруулалт хийгдэх, метан, шатдаг хий, түлш, шахмал түлш болон бусад хими технологийн түүхий эд болох бүрэн боломжтой нь судалгаагаар батлагдсан.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 50 орчим хувийг дангаараа хангаж, эрчим хүч, дулаан хангамжийн системд томоохон хувь нэмэр оруулан ажиллаж байгаа Багануур ХК нь 2023 онд түүхэндээ хамгийн өндөр буюу 4,648.4 мян.тн нүүрс олборлон, түүхэн дээд амжилтаараа 45 жилийн ойгоо угтан, ойн арга хэмжээг шинэлэг, оролцоог хангасан хэлбэрээр зохион байгуулсан нь уурхайн цаашдын хөгжлийг тодорхойлсон томоохон арга хэмжээ болсон.

“Багануур” ХК нь 2023 онд нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн нь уурхайн хамт олны хүчин зүтгэл, хариуцлага, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалт, төлөвлөлтийн үр дүн гэдгийг ОНЦЛОН ТЭМДЭГЛЭЖ, Монгол Улс, нийслэл Улаанбаатар хотын хөгжил, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний сэргэлт, Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж, оюун ухаан, мэдлэг чадвар, туршлага, хүч чадлаа дайчлан ажиллаж байгаа уурхайн нийт хамт олондоо талархсанаа илэрхийлье.

Багануурын уурхай нь Эрдэнэс Монгол нэгдлийн шинэ стратеги төлөвлөлтийн хүрээнд уурхайн үнэт зүйл болох чадварлаг, мэргэшсэн уурхайчид, ажилтнаа эрхэмлэсэн, тэргүүлэх технологи, инновацыг нэвтрүүлсэн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, сайн засаглалыг хангасан, хариуцлагатай уул уурхайг бэхжүүлсэн Монгол Улсын нүүрсний салбарын чиг хандлагыг тодорхойлох үндэсний тэргүүлэгч компани болох эрхэм зорилгодоо амжилттай хүрч чадна гэдэгт илтгэлтэй байна.

Та бүхэнд эрүүл энх, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

АГУУЛГА

Төлөөлөн удирдах зөвлөлийн мэндчилгээ	5
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	6
Алсын хараа, эрхэм зорилго	8
Ерөнхий мэдээлэл	9
Үндсэн үйл ажиллагааны статистик	10
Бүтэц зохион байгуулалт	16
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	19
Хүний нөөц	24
Хөрөнгө оруулалт	28
Байгаль орчны хяналт, нөхөн сэргээлт	32
45 жилийн ойн хүрээнд	36
Орон нутаг, хамтын ажиллагаа	42
Урлаг, спортын чиглэлээр	46
Бусад арга хэмжээ	49
Аудитын тайлан	50





ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



2023 онд Багануурын уурхайн түүхт 45 жилийн ой тохиосон бөгөөд компанийн ойг нэгэн хэвийн байдлаар зохион байгуулахаас татгалзаж компанид үр өгөөжтэй, уурхайн ирээдүй рүү харсан ажил зохион байгуулахыг зорьсон. Ойн хүрээнд инженер техникийн ажилтнуудын дунд үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулах чиглэлээр “MIND MINING BAGAN-UUR 2023” шилдэг төслийн уралдаан, Уурхайчдын хойч үеийг бэлдэх зорилгоор МСҮТ, мэргэжлийн коллежуудын оюутнуудын дунд “Багануур”-ын уурхайн нэрэмжит ур чадварын Улсын уралдаан, шинээр ажилд орсон ажилтнуудын дунд “ХҮНДЭЛБЕ-СУРАЛЦЬЯ-ХУВААЛЦЬЯ” сэдэвт чиглүүлэх сургалт өдөрлөг, Нүүрснээс шинэ бүтээгдэхүүн гаргах боломжийг эрэлхийлэх зорилгоор “THE FUTURE OF COAL BAGANUUR 2023” Олон Улсын эрдэм шинжилгээний хурал, Эрдэнэс Монгол нэгдлийн охин компаниудын ХАБЭА-н ажилтнуудыг хамруулсан “Агаараас эрэн хайх, аврах ажиллагаа”-ны практик сургалтыг зохион байгууллаа.

2023 онд ковидын дараах эдийн засгийн хямрал, ОХУ, Украин Улсын дайны байдал, БНХАУ болон АНУ-ын хориг арга хэмжээнээс үүдэлтэй дэлхий нийтийг хамарсан эрчим хүч, хөдөө аж ахуй, нефтийн бүтээгдэхүүний хомсдолоос шалтгаалсан инфляц, валютын ханшийн өсөлт харьцангуй тогтворжсон ч нэгэнт өссөн үнэ ханш буурахгүй байгаа учраас бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах боломжгүй байлаа.

2023 онд нүүрсний үнэ нэмэгдүүлэх, үнийн зөрүүний алдагдалд төрөөс татаас авах асуудлыг шийдвэрлүүлэхээр ЭХЗХ, ЭХЯ, УУХҮЯ албан бичгээр хандсан ч ЭХЗХ-оос эх үүсвэргүй тул нэмэгдүүлэх боломжгүй гэсэн хариунаас өөр хариу өнөөдрийг хүртэл ирүүлээгүй байна. 2023 онд компани эрчим хүчний станцууд, жижиг хэрэглэгчдэд нийт 4,628.1 мян.тн нүүрс нийлүүлж суурилагдсан хүчин чадлаа 15.7 хувиар давуулан ажиллаж байгаа ч станцуудын гадаах нүүрсний нөөц 5-6 хоногт хүрч 2.8 дахин буурсан нь эрчим хүчний нүүрсний хэрэглээ жил бүр нэмэгдэж байгааг харуулж байна. Бид 2024 онд хөрс, нүүрс тээврийн 60-90тн даацтай 4 автосамосвал, овоолгын 1 гинжит бульдозер, нүүрс олборлолтын 6м³ шанагатай 1 гидро экскаватор, үйлчилгээний зориулалттай ачаа суудлын 4 пикап, 10 тн даацтай 2 крантай ачааны машин, 50 тн-ын даацтай 1 автокран, зөөврийн 1 түлш цэнэглэгч машиныг шинээр худалдан аваад байна. Үүнээс гадна сүүлийн 2-3 жилийн хугацаанд хангалттай хийгдэж чадахгүй байсан технологийн авто машинуудын хөдөлгөөр болон агрегат засварыг 12 машин, илчит тэрэг, төмөр замын краны их засваруудыг хийлээ. Дээрх хөрөнгө оруулалт, засварын ажлуудыг цаг хугацаанд хийж чадсанаар 2023-2024 оны өвлийн ачааллыг харьцангуй өөрсдөөс шалтгаалсан эрсдэлгүй давж чадлаа.

2023 онд Эрдэнэс Монгол ХХК, ТУЗ-ийн дэмжлэгтэйгээр компани ажилтнуудын цалинг 2

удаа 30%-иар, 2024 оны 1 сараас дахин 10%-иар нэмэгдүүлж ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг өөрийн нөөц бололцооны хэмжээнд шийдвэрлэснээс гадна 2008 оноос хойш шинэчилж чадаагүй байсан “Цалингийн сүлжил”-ийг шинэчлэн хэрэгжүүлж чадлаа. 2022 онд компанийн хэмжээнд нийт 69 тендер зарлагдаж 29 тендер шалгаруулалт л амжилттай болж байсан бол тайлант онд нийт 156 тендер зарлагдаж 124 тендер амжилттай болж худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд явууллаа.

Бид 2023 онд компанийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж дууссан бөгөөд Эрдэнэс Монгол ХХК-ийн техникийн зөвлөлийн хурал, ТУЗ-ийн хуралд танилцуулж, одоогоор УУХҮЯ-ны АМГ-ын ЭБМЗ-өөр хэлэлцэгдэж байна.

2022-2023 оны өвөл Багануур дүүрэг, түүний ойр орчмын сумдуудад ихээхэн хэмжээний цас зудын байдалтай байсан тул уурхайчдын “Халуун сэтгэлийн аян”-ыг амжилттай зохион байгуулж, тусламжийг цаг алдалгүй хүргэсэн. Мөн Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг”-т дүүргийн 60 байгууллага, аж ахуйн нэгжээс 93.8%-иар ДҮҮРЭН ХАНГАЛТТАЙ үнэлгээ авч тэргүүлээ.

Компани цаашид үйлдвэрлэлийн үйл ажиллагааг шинжлэх ухааны баримжаатайгаар явуулахын тулд Монгол Улсын ШУТИС, Герман Монголын хамтарсан GMIT сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд: 2023 онд үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа болох нүүрс гаргалтын төлөвлөгөөг 100.5%, борлуулалтын төлөвлөгөөг 100.1 хувь, хөрс хуулалтын төлөвлөгөөг 102.1 хувь, нийт уулын цулын төлөвлөгөөг 103.7 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн бол санхүүгийн орлогын төлөвлөгөөг 99.1 хувь, зардлын төлөвлөгөө 99.0 хувь, алдагдал 97.4 хувь буюу төлөвлөсөн алдагдлыг 2.4 хувиар бууруулан ажиллаа.

2024 онд хийх ажлын талаар: 2024 онд 20,390.0 мян. м³ хөрс хуулж, 5,500.0 мян.м³ ус шавхан зайлуулж, 4,734.0 мян.тн нүүрс олборлож, нийт 30,743.1 мян.м³ уулын цулын ажлыг хийхээр төлөвлөгөөг боловсруулан өмнөх оны гүйцэтгэлээс хөрс хуулалт 2,895.0 мян.м³, үүнээс тээвэргүй хөрс хуулалт 818.3 мян.м³-ээр буурсан бол авто хөрс хуулалтын хэмжээ 3,458.4 мян.м³-ээр өсөж байна. Авто хөрс хуулалтын хэмжээ 22.2%-иар нэмэгдэж байгаагаас нүүрсний өртөг зардлын хэмжээ нэмэгдэх нөхцөлийг бодитоор үүсгэж байна.

2024 онд 242 тэрбум 839.5 сая төгрөгийн орлого олж 250 тэрбум 691.2 сая төгрөгийн зардал гарган, 7 тэрбум 851.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөж байна.

2024 оны бизнес төлөвлөгөөнд Эрчим хүчний дулаан болон цахилгаан станцуудад борлуулах нүүрсний үнийг 7 дугаар сарын 1-ний өдрөөс 7,690.0 төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөсөн учраас “Эрчим хүчний зохицуулах хороо” болон холбогдох эрх бүхий байгууллагуудад нүүрсний үнэ нэмэгдүүлэх хүсэлтийг тавих эсвэл үнийн зөрүүний алдагдалд татаас авах саналыг шийдвэрлүүлэх, мөн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт туссан тоног төхөөрөмжүүдийн шинэчлэлд шаардлагатай санхүүжилт, МУ-ын Засгийн газрын 2018 оны 132 тоот тогтоолд дурдсан “Монгол нүүрс” төслийн зээлийг хөрөнгө оруулалтаар бүртгүүлэх зэрэг томоохон ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Ингээд 2023 онд биднийг дэмжин ажилласан хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ын гишүүд, толгой компани, төр захиргааны байгууллага болон харилцагч байгууллагууддаа баярлаж талархсанаа илэрхийлэхийн ялдамд цаашид илүү урт удаан хугацаанд хамтран ажиллаж өндөр амжилтад хамтдаа хүрнэ гэдэгт бид итгэж байна.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ТҮВШИНЖАРГАЛ



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



ЭРХЭМ ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацад суурилсан үндэсний тэргүүлэгч компани болно.

АЛСЫН ХАРАА

Монгол Улсын нүүрсний салбарын чиг хандлагыг тодорхойлогч байна.

ҮНЭТ ЗҮЙЛ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Бид хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг нэн тэргүүнд тавьдаг

ХАРИУЦЛАГА

Бид үүрэг хариуцлагаа ухамсарлаж хийж буй үйлдэл хэлсэн үгэндээ эзэн болдог.

ШУДАРГА ҮНЭНЧ

Бид зөв зүйлийг хийж, шударга ил тод байдаг. Өөртөө болон бусдад зарчимч байдлаар хандаж, шударга бус байдалтай үл эвлэрнэ.


БАГЫН АЖИЛЛАГАА, ХАМТЫН ХҮЧ

Бид харилцан итгэлцэл хүндлэлийг бий болгон хүн бүр багийн нэг хэсэг болж үр дүнтэй хамтран ажилладаг.

САНААЧЛАГЧ, БҮТЭЭЛЧ, СУРАЛЦАГЧ

Бид мэргэжилдээ хүндэтгэлтэй хандан, санаачилгатай байж, шинэ шийдэл ажлын шинэ арга замыг бүтээлчээр хөгжүүлж, мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулахын тулд мэдлэг ур чадвар чадвараа байнга дээшлүүлдэг.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭЗЛЭМЖ



ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК

4,648.4

МЯН.ТН НҮҮРС ГАРГАВ

100.5%

4,628.1

МЯН.ТН НҮҮРС БОРЛУУЛАВ

100.1%

17,866.7

МЯН.М³ ХӨРС ХУУЛАВ

102.1%


29,098.1

МЯН.М³ УУЛЫН АЖИЛ ХИЙВ


103.7%

УУЛЫН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ


НҮҮРС БОРЛУУЛАЛТ /сая.тн/




ХӨРС ХУУЛАЛТЫН КОЭФФИЦИЕНТ /кхх/




ХӨРС ХУУЛАЛТ /сая.м³/




УС ШҮҮРҮҮЛЭЛТ /сая.м³/



УУЛЫН ЦУЛ /сая.м³/




ТЭСЭЛСЭН УУЛЫН ЦУЛ /сая.м³/




“Багануур” ХК-ийн нүүрсний борлуулалт сүүлийн 3 жилд дунджаар 4.6% хувиар өсөж байгаа бөгөөд 2023 оны байдлаар 4,625.0 мян.тн нүүрс олборлож, борлуулах төлөвлөгөөтэй ажиллан, 4,648.4 мян.тн нүүрс олборлон 100.5%, 4,628.1 мян.тн нүүрс борлуулан 100.1%-ийн гүйцэтгэлтэй, 17,495.0 мян. м³ хөрс хуулах төлөвлөгөөг 102.1%-р биелүүлэн 17,866.7 мян.м³ хөрс хуулсан. Нийт 28,058.9 мян. м³ уулын цулын ажил гүйцэтгэхээс 29,098.1 мян.м³ уулын цулын ажил хийж төлөвлөгөөт зорилтыг 103.7%-иар биелүүлэн, дэвшүүлсэн зорилтоо үзүүлэлт тус бүрээр давуулан биелүүлж ажиллаа.

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


НИЙТ ОРЛОГО /сая.төг/




НҮҮРСНИЙ ӨРТӨГ /мян.төг/




НИЙТ ЗАРДАЛ /сая.төг/




УС ШҮҮРҮҮЛЭЛТ /сая.м³/



АШИГ, АЛДАГДАЛ /сая.төг/



ТӨСӨВТ ТӨЛСӨН ТӨЛБӨР /сая.төг/




“Багануур” ХК-ийн борлуулалтын орлого сүүлийн 3 жилд дунджаар 14.7% хувиар өссөн бөгөөд 2023 оны байдлаар нийт 214.6 тэрбум төгрөгийн орлого олж 224.4 тэрбум төгрөгийн зардал гаргаж 9.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 212.6 тэрбум төгрөгийн орлого олж 222.1 тэрбум төгрөгийн зардал гарган 9.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллан, төлөвлөсөн алдагдлыг 249.0 сая төгрөгөөр өмнөх жилээс алдагдлыг 24.1 тэрбум төгрөгөөр буурууллаа.


ХУДАЛДАН АВАЛТ, ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

“Багануур ХК” 2022 онд 69 тендер зарласнаас 29 тендер амжилттай болж байсан бол, 2023 онд 156 тендер зарласнаас 124 нь амжилттай болсон. Энэ нь Багануур ХК харилцагчдынхаа итгэлийг нэмэгдүүлсэн үйл явдал хэдий ч цаашид үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн найдвартай явуулахын тулд нүүрсний үнийг нэмэгдүүлж, мөнгөн хөрөнгийн дутагдлыг бууруулах нэн шаардлагатай байна.

ЗАРЛАСАН ТЕНДЕРИЙН ТОО



АМЖИЛТТАЙ ТЕНДЕРИЙН ТОО



2023 онд дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 635.0 сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн. Үүнд:

- Ажлын хувцас /Хүйтний улирлын/
 - Ажлын хувцас /Дулааны улирлын/
 - Ажлын гутал /Дулааны улирлын/
 - Ажлын гутал /Хүйтний улирлын/
 - Ажлын цамц
 - Дархлаа дэмжих бүтээгдэхүүн
- Өвөр Ундарга ХХК
 - Их Газрын Чулуу ХХК
 - Бестшүес ХХК
 - Бестшүес ХХК
 - Их Газрын Чулуу ХХК
 - Баялаг Өөдөс ХХК
- 124.5 сая төгрөг
 - 106.8 сая төгрөг
 - 108.7 сая төгрөг
 - 119.7 сая төгрөг
 - 66.5 сая төгрөг
 - 108.8 сая төгрөг






**МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВТ НЭГ
АЖИЛТНЫ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ
НЭМЭР 42 САЯ ТӨГРӨГ**

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн орон тоог Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2023 оны А/04 тоот тушаалаар баталж 7 хэлтэс, 3 алба, 9 хэсгийн нийт 1123 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Компанийн удирдах дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл байна. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал, захирлын зөвлөл удирдан зохион байгуулна.



КОМПАНИЙН УДИРДЛАГА



Д.ТҮВШИНЖАРГАЛ
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч



Н.БАЗАРСҮРЭН
Үйлдвэр, технологи эрхэлсэн дэд захирал



А.ЭНХБОЛД
Техникийн бодлого эрхэлсэн дэд захирал



Д.ДАВААДАШ
Хүний хөгжил, судалгаа эрхэлсэн дэд захирал



Ч.НАРАНБАТ
Технологийн бодлогын хэлтсийн дарга



Т.АМАРСАНАА
Техникийн бодлогын хэлтсийн дарга



Ч.АРИУНБААТАР
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга



Ж.БОЛД-ЭРДЭНЭ
Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтсийн дарга



Д.ХИШИГДЭМБЭРЭЛ
Худалдаа хангамж хариуцсан хэлтсийн дарга



Б.БАТБОЛД
Захиргаа хүний нөөц, удирдлагын хэлтсийн дарга



Х.ХАШБАТ
Судалгаа хөгжлийн хэлтсийн дарга

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ



“Багануур” ХК нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.2 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого (2021–2023), ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо стандарт шаардлагын хүрээнд тайлант хугацаанд 1 бодлогын баримт бичиг /ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэх гарын авлага/, 1 журам /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх журам/ шинээр боловсруулж, 1 журманд /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шагнал урамшууллын журам/ нэмэлт өөрчлөлт оруулж батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хийж хэрэгжүүлэх ажлыг 2023 онд 6 зорилтын хүрээнд 27 заалттай төлөвлөгөөг гарган 100%-ийн гүйцэтгэлтэй ажиллаа.

МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ДОТООД АУДИТ

Дотоод аудит хийх гэдэг нь компанийн хэрэгжүүлж буй Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо нь ISO 45001:2018 стандартын шаардлагад хэрхэн тохирч байгаа, хэр зэрэг үр нөлөөтэй, хэвийн ажиллагааг хангаж байгаа эсэхэд аудит хийх үйл ажиллагааг ойлгодог.

“Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/182 тоот тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоонд аудит хийх журам”-ыг үндэслэн 2023 оны 5-р сарын 15-наас 30-ны өдрүүдэд компанийн 3 хэсэг, 6 хэлтэс 2022 оны Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хэрэгжилтийн байдалд дотоод аудитыг 3 дэд багийн бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн. Нэгж тус бүрийг шалгах хуудасны 36 шалгуур үзүүлэлтээс, холбогдох 36 шалгуураар үнэлэхэд нийт залруулах, сайжруулах шаардлагатай 26 жижиг үл тохирол гарсан ба том үл тохирол гараагүй.

Компанийн Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны дотоод аудитын нэгдсэн үнэлгээгээр тохирол 91.9 %, том үл тохирол 0, жижиг үл тохирол 8.1% буюу ХАНГАЛТТАЙ гэсэн үзүүлэлт гарсан.

ISO 45001:2018 стандартын хэрэгжилт “ХАНГАЛТТАЙ” гэж дүгнэж холбогдох нэгжид сайжруулах санал, хувилбар, зөвлөмжийг хүргүүлсэн.

НЭН ТЭРГҮҮНД АЮУЛГҮЙ БАЙДАЛ





МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭМЖИЛТ МОНИТОРИНГ

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2022 оны 03 сарын 09-ний өдрийн А/109 тоот тушаалаар томилогдсон гүйцэтгэлийн хэмжилт мониторингийн баг 2022 оны 3, 4-р улирал, 2023 оны 1, 2-р улирлын гүйцэтгэлийн хэмжилт хийж гүйцэтгэсэн.

Тус хэмжилтээр компанийн 9 хэсгийн 135 ажлын байр болон 42 ахуйн байрыг хамруулсан. Компанийн “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын үйл ажиллагааны гүйцэтгэлийн хэмжилт мониторинг”-ийн нэгдсэн үнэлгээгээр 100 хувиас дунджаар 88 хувьтай үнэлэгдсэн тул хэрэгжүүлж буй Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, хяналтыг САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ гэж дүгнэгдсэн.

МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ УДИРДЛАГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны тохиромжтой, нийцтэй, өгөөжтэй байдал, бодит нөхцөл байдлын өөрчлөлт, эрэлт хэрэгцээг хангаж буй

эсэх, дотоод аудит, мониторингоос илэрсэн үл тохирол, залруулалтыг гүйцэтгэх удирдлагад танилцуулж, дүгнэлт гаргуулах удирдлагын дүн шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан.

2022 оны Удирдлагын дүн шинжилгээний хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 12 ажлаас 8 ажил 100%-ийн биелэлттэй, ТАМЗХ, ЗХ-ийн заалны агааржуулалтыг стандартын шаардлага хангуулах 2 ажил 70%-ийн биелэлттэй. YAMX-ийн агааржуулалтын системийг ажилд оруулах, ЗХ-ийн халуун төмөрчний өрөөг стандартын шаардлагад нийцүүлэх 2 ажил хөрөнгө санхүүгийн эх үүсвэргүй улмаас хийгдээгүй бөгөөд төлөвлөгөөний гүйцэтгэл 78.3%-ийн биелэлттэй байна.

2023 оны Удирдлагын дүн шинжилгээний хурлаар өмнөх хурлын шийдвэрийн хэрэгжилт, тайлант хугацааны гүйцэтгэлийн хэмжилт, мониторинг, аудитын дүгнэлт, үл тохирлыг хэлэлцэн “хэрэгжүүлж буй ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны стандарт өгөөжтэй, эрэлт хэрэгцээг хангаж байна” гэж дүгнэсэн, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх 7 заалттай төлөвлөгөө гарган Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр батлуулан ажилласан.

Ажлын байрны сөрөг хүчин зүйлийг залруулах, төсөв хөрөнгө шаардлагатай 4 ажил төлөвлөснөөс 100%-ийн гүйцэтгэлтэй ажил 1, 50%-ийн гүйцэтгэлтэй 2, гүйцэтгэл хангалтгүй 1 ажил байна.


Үйлчилгээний автомашины хэсгийн агааржуулалтын системийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх төсөв, зураг төслийн дагуу хийх ажлын төсвийг компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөнд тусгуулаагүй.

Зохион байгуулалт шаардлагатай 3 ажил төлөвлөснөөс 100%-ийн биелэлттэй 1, 20%-ийн биелэлттэй 1, хугацаа болоогүй 1 ажил байна.


ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЭЭЛЖИТ ҮЗЛЭГ

2023 онд компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ээлжит III шатны үзлэгийг 4 удаа хийж, 173 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оноос 15-иар /2022 онд 147 зөрчил/ өссөн, зөрчил арилгах албан шаардлагыг холбогдох удирдлагуудад өгч, илэрсэн зөрчлийн 97%-ийг бүрэн арилгуулж ажилласан.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ



ЗӨРЧИЛ АРИЛГАСАН ХУВЬ



ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

2023 онд “Хэлт энд сэфти солушинс” ХХК-тай гэрээ байгуулж, 137 ажлын байранд хөдөлмөрийн эрүүл ахуйн 22 үзүүлэлтээр нарийвчилсан хэмжилт, эрсдэлд суурилсан ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэсэн.

Дээрх хэмжилтийн шуугиан, доргион, бичил цаг уурын үзүүлэлтүүд, утаа, тоос, тоосонцор агаарын чанарын зарим үзүүлэлтүүдийг шууд хэмжилтийн багажаар, нэг хүнд ногдох талбай, эргономикийн эрсдэлийг хяналтын хуудас болон ажиглалт, тооцооллын аргаар хэмжиж үнэлсэн.

Хэмжилт, үнэлгээнд хамрагдсан 137 албан тушаалын 20 нь дунд буюу эрсдэлгүй, 41 нь өндөр, 74 нь ноцтой буюу эрүүл мэндэд эрсдэлтэй хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй байна.

Компанийн ажлын байр, тоног төхөөрөмжүүдэд хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтийг батлагдсан хуваарийн дагуу давхардсан тоогоор 289 удаа хийхэд 39 ажлын байранд 61 сөрөг хүчин зүйлс илэрсний 72% буюу 44 сөрөг үзүүлэлтийг 10 хэсэг, 1 албанд хугацаатай үүрэг даалгавар өгч арилгуулан стандартын шаардлага хангуулсан.

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДАЛТЫГ БУУРУУЛАХ, ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Амбулаториор 1400 гаруй ажилтныг үзэж зөвлөгөө өгөн, эмчилгээ сувилгаанд хамруулж, хяналтын бүлгийн 164 ажилтныг шаардлагатай үзлэг шинжилгээнд хамруулан эрүүлжүүлэх төлөвлөгөө гаргасан.

Үүнээс эрүүлжилтийн хувь 2 %, архаг өвчний намжмал буюу сэдэрлэлт өгөөгүй 21% байна. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн уламжлалт нөхөн сэргээх тасагтай хамтран стационарт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай 53 ажилтныг хэвтүүлэн эмчлүүлсэн.

Хөдөлмөрийн чадвар түр алдалт өнгөрсөн 2022 оноос 7 %-иар буурсан.


1123 АЖИЛТНЫГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАЖ БАЙНА




ХҮНИЙ НӨӨЦ

ХҮНИЙ НӨӨЦИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ


ХҮЙСИЙН ХАРЬЦАА




НАСНЫ БҮЛЭГ



БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



АЖИЛЛАСАН ЖИЛ



2023 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, стандарт, дүрэм журам, бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үндсэн орон тоог 1123 ажилтанд барьж ажилласан. Үүний: 147 эмэгтэй, 976 эрэгтэй, 297 ажилтан хэвийн, 826 ажилтан хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаагаас удирдлага – 24, мэргэжилтэн – 86, ИТА–80, туслах ажилтан–25, үйлчилгээний ажилтан 109, мэргэжлийн ажилтан –799 ажилтан байна.

Нийт ажилтны 38% нь дээд, 47% нь бүрэн дунд боловсролтой, 11% нь тусгай дунд, 4% нь бүрэн бус дунд боловсролтой байна. Үүнээс 71 ажилтан магистр, 25 ажилтан мэргэшсэн, 7 ажилтан зөвлөх инженер, 1 ажилтан докторын зэрэгтэй байна.

Ажилласан жилээр харьцуулбал нийт ажилтны 47% нь 0–10 н жил, 32% нь 11–20 жил, 21% нь 21–с дээш жил ажилласан байгаагаас харахад компанийн ажилчдын хувьд нэг үе солигдож байгааг харуулж байна.

2023 онд байгууллагын хөгжлийн хандлага, уурхайчдын үе солигдож байгаатай уялдуулан хүний нөөцийг чадавхжуулах, хөгжүүлэх, ажлын байр сэлгэн ажиллуулах, ёс зүйг эрхэмлэсэн, мэргэшсэн, чадварлаг ажилтнуудыг төлөвшүүлэх, тэдний нийгмийн баталгааг хангах, ажлын байранд

болон ажлын байр сэлгэн ажиллуулах сургалтыг түлхүү хэрэгжүүлж ажиллаа. Үүнээс гадна ажилтнууд залуужиж байгаатай холбоотойгоор тэдгээрийн нийгмийн асуудалд дэм тус болох бодлогыг компаниас хэрэгжүүлэх шаардлагыг үүсгэж байна.

Тайлант онд компанийн хэмжээнд оролтын коэффициент 6,4 хувьтай байна. 2023 онд ажилд 72 ажилтан шинээр томилогдсон. Үүнээс 30 ажилтан буюу 42 хувийг нээлттэй сонгон шалгаруулалтаар, 15 хувийг дотооддоо болон гэрээт ажилтнуудаас томилсон. Харин 77 ажилтан ажлаас чөлөөлөгдсөний 46 ажилтан өөрийн хүсэлтээр, 11 ажилтан захиргааны, 5 ажилтан өндөр насны тэтгэвэрт, 9 ажилтан МШӨ группэд, 6 ажилтан бусад шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн.

Тухайн онд ажлын байрны шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор хүний нөөцийн бодлогын хүрээнд байнгын 220 ажилтан, түр албан тушаал шилжин ажилласан 198 ажилтантай холбоотой хөдөлгөөн хийгдсэн. Энэ нь ажилтнуудын албан тушаал дэвших, зэрэг ахих, буурах болон хөндлөн шилжилт байлаа.

Компанийн хэмжээнд 2023 онд 79 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан байна. Үүнд өөрт

ганцаарчилсан хэлбэрээр сануулах сахилгын шийтгэл–12, нийт ажилтнуудад зарлах хэлбэрээр нээлттэй сануулах сахилгын шийтгэл–2, үндсэн цалинг 1 сарын хугацаатай 20 хувь бууруулах сахилгын шийтгэл–24, үндсэн цалинг 2 сарын хугацаатай 20 хувь бууруулах сахилгын шийтгэл–19, үндсэн цалинг 3 сарын хугацаатай 20 хувь бууруулах сахилгын шийтгэл–22 тус тус ногдуулсан байна.

2023 онд компанийн вэб хуудас болон пейж хуудсан дээр нээлттэй 19, компанид ажиллаж байгаа ажилтнуудад (дотооддоо) 11 ажлын байран дээр сонгон шалгаруулалт зарласан.

2023 онд хүний нөөцийн тогтворжилтын коэффициент 93,5% байсан нь өмнөх онтой харьцуулахад өөрчлөлтгүй байлаа.

2023 онд давхардсан тоогоор 5170 ажилтан сургалтанд хамрагдсан байна. Дээрх сургалтуудыг зохион байгуулахад 110,6 сая.төгрөг төлөвлөснөөс 92,9 сая.төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Зохион байгуулсан сургалт:

- Ажилтнуудын ерөнхий мэдлэг, ур чадвар дээшлүүлэх – 3640 ажилтан,
- ИТА–ны мэргэжил дээшлүүлэх – 356 ажилтан
- Ажилтнуудын мэргэжлийн зэргийг ахиулах, мэргэшүүлэх – 25 ажилтан
- Техник ашиглалтын дүрэм, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа /допускын/ эрх олгох, сунгах сургалт – 295 ажилтан
- Тусгай эрх олгох, эрх сунгах – 435 ажилтан
- ХАБЭА–н сургалт, Сургагч багш – 981 ажилтан
- Туршлага судлах – 298 ажилтан
- Ажлын байранд дадлагуулах, мэргэжил дээшлүүлэх – 30 ажилтан




49.9 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭВ



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ



2023 оны бизнес төлөвлөгөөнд ТАМ-ын засварын байрыг 1,945.2 сая төгрөгийн өртөгтэйгөөр барьж байгуулахаар төлөвлөсөн боловч тендер шалгаруулалтын процессоос шалтгаалан он дамжин хийгдэхээр боллоо. Харин тайлант оны 10ш, өмнөх оны үлдэгдэл 6ш гүний цооногийг өрөмдүүлж ашиглалтад хүлээн аваад байна. Ойрын хугацаанд уурхайд нэн чухал байгаа дэд бүтцийн шинжтэй Технологи дамжлага №3-ыг ашиглалтад оруулах шаардлагатай байгаа бөгөөд тус төслийн барилгын зургийн тендер шалгаруулалтыг 2023 онд зарласан боловч шаардлага хангасан оролцогч байгаагүй.

эх үүсвэрээр үндсэн үйлдвэрлэлд ашиглах зорилгоор хөрс, нүүрс тээврийн 60-90 тн даацтай 4 автосамосвал, овоолгын 1 гинжит бульдозер, нүүрс олборлолтын 6м³ шанаганы багтаамжтай 1 гидро экскаватор үйлчилгээний туслах үйл ажиллагааны зориулалтаар ачаа суудлын 4 пикап, 10тн даацтай 2 крантай машин, тусгай зориулалтын 50 тн даацтай 1 автокран, зөөврийн түлш цэнэглэх зориулалттай 1 цистерныг ашиглалтад шинээр авсан. 2021 оноос хойш хүлээгдээд байсан 10 ТАМ-ын хөдөлгүүр болон агрегат засвар, Илчит тэрэг, төмрийн краны их засварыг бүрэн хийж чадлаа.

2023 онд компани өөрийн санхүүгийн





**МОНГОЛ УЛСЫН НӨХӨН
СЭРГЭЭЛТ ХИЙСЭН
АНХДАГЧ УУРХАЙ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнд Багануур ХК нэгдэж нэг сая мод тарина. Багануур ХК нь 960 мянган ширхэг суулгацыг үржүүлэн 2026 оноос өөрсдийн суулгацыг хангахаар төлөвлөсөн хэдий ч 2023 оны тарих модыг өөрсдийн үржүүлсэн улиас, хайлаасны суулгацаас тарьж эхэлсэн. “Нэг тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд манай компани хавар, намрын мод тариалалтаар 2023 онд нийт 11637 ширхэг мод тариалаад байна.

НӨХӨН СЭРГЭЭЛТ

2023 онд дотоод овоолгын нөхөн дүүргэлтийг Уул-1 хэсэгт 1,797.8 мян.м3, Уул-2 хэсэгт 777.0 мян.м3, нийт 2,574.8 мян.м3 хөрсөөр хийлээ.

Уулын ажлын онцлогоос хамааран уулын ажлын эцсийн хүрээ хязгаарын дагуу овоолгууд хэлбэржээгүй тул биологийн нөхөн сэргээлтийн оронд дүйцүүлэн хамгаалал болон Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжиж мод бут тарих ажлуудыг хийж байна. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Аваргын голын урсац бүрэлдэх хөндлөн булгийн эхийг хашиж хамгаалах, Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхэд залуучуудын спорт хөгжлийн талбайд 3200ш хайлаас модыг суулгах ажлыг хийсэн.



2023 онд Багануур дүүргийн “Боловсрол цогцолбор” ЕБС-ийн 6-12-р ангийн нийт 43 ангийн 1100 гаруй сурагчдад Байгаль орчин, мод тарих арга, хог хаягдлын талаар сургалтыг хийсэн.

Компанийн 9 хэсгийн нийт 673 ажилтанд мод бут тарих арга, арчилгааны талаарх сургалтыг орсон байна.

2023 онд 45 жилийн ойн зочид төлөөлөгчдөд болон Багануур дүүргийн 5 хорооны иргэдийн төлөөлөлд Нөхөн сэргээлт, Тэрбум үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа Мод үржүүлгийн газрын үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгуулсан.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлын менежментийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан.

Үүнд:

- Ахуйн хог хаягдлыг “Багануур тохижилт” ОНӨААТҮГ, Татварын албатай гэрээ байгуулан төвлөрсөн хогийн цэгт хаяж байна. Дахивар хаягдлыг ангилан тушааж байна. 2023 онд хуванцар 133кг, цаас 164.5кг, кардонон цаас 13кг тус тус хэсгүүдээс хүлээн авч тушаасан.
- Хог хаягдлыг ангилан ялгах, хаягдал хогуудаас сэлбэгийн хогийг ялган ашиглах боломжтойг авч үлдэн, ашиглах боломжгүйг нь 2 дахь түүхий эдийн хашаанд хадгалж байна. Ашиглах боломжтойг журмын дагуу шаардахаар авч ашиглаж байна. 2023 онд 29 нэр төрлийн 12432 нэгж хог хаягдлыг дахин ашигласан байна.

- 2023 онд Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эрх бүхий “Эко стандарт петролиум” ХХК-тай гэрээ байгуулан 228тн ажилласан тос маслыг тушаасан. Тос маслыг бүрэн тушааж дуусаагүй байгаа тул хөрсийг хусаж цэвэрлэх ажил хойшлогдоод байна.
- Цэгүүдэд байрлуулсан бохир хөрс цуглуулах савны ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, бохир хөрсийг хөрс саармагжуулах талбайд 3 удаа цуглуулан саармагжуулсан.
- Компанийн нийт ажилтнууд хамрагддаг “ХАБЭА сургалтын хөтөлбөр”-т хог хаягдлын сургалтыг оруулж сар бүрийн 3 дахь 7 хоногт хичээлийг өдөрт 2 удаагийн давтамжтайгаар зохион байгуулсан.

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ



45 ЖИЛИЙН ТҮҮХТЭЙ
ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУЛГУУР
УУРХАЙ



45 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД

THE FUTURE OF COAL BAGANUUR 2023

“Багануур ХК”-ийн 45 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан “THE FUTURE OF COAL BAGANUUR 2023” олон улсын эрдэм шинжилгээний хурал, бизнес хамтын ажиллагааны өдөрлөг 2 өдөр амжилттай болсон. 8-р сарын 24, 25-ны өдрүүдэд болсон уг арга хэмжээ нь Багануур ХК өнгөрсөн, одоо, ирээдүйн 3 цаг дээр тулгуурлан цаашдын хөгжлийнхөө чиглэлийг тодорхойлох зорилго агуулсан юм.

Эхний өдрийн сэдэв “Нүүрсний ирээдүй”. Энэ сэдвийн хүрээнд нүүрсийг зөвхөн илч гаргахад ашиглах бус боловсруулж, нэмүү өртөг шингээснээр уурхай цаашид орлогын хувьд хос морьтой болох боломж шийдлүүдийн талаар эрдэмтэд судлаачид шийдэл хайж зөвлөлдөж илтгэл хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Хоёр дахь өдрийн эрдэм шинжилгээний хурал Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуй сэдвээр үргэлжилсэн. “Эрдэнэт үйлдвэр”ТӨҮГ, “Эрдэнэс таван толгой” ХК, “Таван Толгой Түлш” ХХК зэрэг 10-аад байгууллагын ХАБЭА-н мэргэжилтнүүд оролцож өөрсдийн байгууллагынхаа сайн туршлагыг хуваалцаж илтгэл танилцуулсан.

Компанийн хувьд 45-н жилийн ойгоо баяр наадам, баярын хурал, шагнал урамшуулал гардуулах байдлаар биш ирээдүйнхээ хөгжлийг тодорхойлсон үр дүнтэй эрдэм шинжилгээний хурал, хамтын ажиллагааны өдөрлөг зохион байгуулсан нь онцлог болсон юм. 2 өдрийн арга хэмжээнд 27 аж ахуйн нэгжийн 300 гаруй оролцогч оролцсон. Эхний өдрийн илтгэл, хэлэлцүүлгийг МҮОНРТ-ээр шууд дамжуулсан.



Олон улсын эрдэм шинжилгээний хурал, бизнес хамтын ажиллагааны өдөрлөгийн 2 дахь өдөр болсон онцгой нэгэн арга хэмжээ бол Онцгой байдлын ерөнхий газар, Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа 111-р анги, Зэвсэгт хүчний жанжин штаб, Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа 303-р анги, 084-р анги, Хилийн цэргийн 0252-р ангиудтай хамтарсан үзүүлбэр байлаа. Тухайлбал:

- Онцгой байдлын ерөнхий газрын Турк улсад болсон газар хөдлөлтийн гамшгийн үед аврах ажиллагаанд оролцсон нохойн үзүүлбэр
- Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн нисдэг тэрэгтэй аврах ажиллагааны үзүүлбэр
- Шүхрийн үзүүлбэр
- “Багануур ХК”-ийн тоног төхөөрөмжийн үзүүлэн
- Багануур дүүргийн онцгой байдлын хэлтсийн тоног төхөөрөмжийн үзэсгэлэн
- Хилийн цэргийн 0252-р ангийн тусгай багаж хэрэгслийн үзүүлэн нь олон улсын эрдэм шинжилгээний хурал, бизнес хамтын ажиллагааны өдөрлөгт оролцсон зочид төлөөлөгчид, уурхайчдын хайр хүндлэл, бахархал, гайхширлыг төрүүлсэн үйл явдал болсон юм.

Мөн хоёр өдрийн арга хэмжээний үеэр компани ШУТИС-ийн ГУУС-тай, Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуультай хамтын ажиллагааг улам өргөжүүлэх чиглэлээр санамж бичиг байгуулсан.

Түүнчлэн форумын үеэр уурхайн гадна талбайд Их дээд сургууль, МСҮТ, Уул уурхайн бараа бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч компаниуд 7 гэр, 15 асар майханд өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ танилцуулсан.

MIND MINING BAGANUUR 2023

2023 онд Багануурын уурхайн түүхт 45–н жилийн ой тохиосон ба уурхайн удирдлагын зүгээс тус ойг нэгэн хэвийн тогтсон байдлаар тэмдэглэхээс татгалзаж аль болох үр өгөөжтэй байх хэлбэрээр зохион байгуулахыг хичээсэн.



Байгуулагдаад 45 оныг түүчээлэх хугацаандаа Багануурын уурхайчдад ололт амжилт, арвин их туршлага, шинэ санаа, санаачилга, ажлын их дэвшил олон байсан. Гэсэн хэдий ч Дэлхий дахинд төдийгүй Монгол улсад уул уурхай хурдацтай хөгжихийн хирээр Багануур ХК-ийн уурхайчин хамт олон улам ихийг хийх бүтээх, санах, санаачлах шаардлага байнга урган гарч байна.

Аливаа байгууллага ажилтнуудаасаа гарч байгаа оюуны болоод биеийн хүчний чадавх,

бүтээлч сэтгэлгээ, оновчтой шийдэл, санаачлагыг дэмжиж, тэдгээрийг төрийн бодлоготой уялдуулан шинэ хариуцлага, ахиц дэвшил гаргахыг эрмэлзэн ажилласнаар хөгжиж, үйл ажиллагаагаа өргөжүүлдэг. Энэ ч утгаараа “Багануур ХК” 45 жилийн ойгоо тохиолдуулан олон талт ажлыг жилийн турш зохион байгуулсны нэг нь MIND MINING BAGANUUR 2023 шилдэг төсөл шалгаруулах уралдаан юм. Байгууллагадаа тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, шинэ санал санаачилга гаргах, инженер техникийн ажилтнуудын мэдлэг чадвар, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор зохион байгуулсан энэхүү уралдаан 2023 оны 6–р сард эхлэн 4 сар үргэлжлээд 2023.10.10–ны өдөр дүнгээ гаргалаа. Багануур ХК-ийн 165 инженер техникийн ажилтан санамсаргүй түүврийн аргаар 11 багт хуваагдан, өгөгдсөн сэдвүүдээс өөрсдийн сонгосон сэдвийн дагуу төсөл бичиж, хамгааллаа.



УР ЧАДВАР БАГАНУУР 2023

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрын зөвшөөрөлтэйгөөр Налайх дүүрэг дэх политехникийн коллеж, Трансвест Монголиа ХХК-тай Багануур ХК хамтран Мэргэжлийн сургууль болон Политехник коллежийн суралцагчдын дунд “УР ЧАДВАР БАГАНУУР 2023” улсын уралдаан зохион байгуулсан. 2023.10.12–ны өдөр болсон энэхүү ур чадварын улсын уралдаан Тогооч, Хүнд машин механизмын оператор, Металл боловсруулах суурь машины оператор гэсэн 3 мэргэжлийн ангиллаар зохион байгуулагдлаа. Уралдаанд Дорнод, Хэнтий, Өмнөговь, Дархан–Уул, Орхон, Төв зэрэг аймгуудаас гадна Улаанбаатар, Налайх дүүрэг дэх мэргэжлийн сургууль, коллежуудын 40 гаруй оюутан сурагчид хүрэлцэн ирж оролцоо.

Хүнд машин механизмын оператор мэргэжлийн суралцагчдыг бэлтгэдэг мэргэжлийн сургуулиудын суралцагчдын мэргэжлийн ур чадварыг сорих, харилцан туршлага солилцох, техник дээр ажиллах чадварыг сайжруулах, ажил олгогч байгууллагууд, мэргэжлийн сургуулиудын хамтын ажиллагааг сайжруулах зорилготой уг уралдаан Багануур ХК-ийн технологийн автомашины ашиглалтын хэсгийн талбайд болсон.

Металл боловсруулах суурь машины оператор буюу токарьчин мэргэжлийн уралдаанд Дархан–Уул, Өмнөговь, Орхон, Бор–Өндөр, Улаанбаатар хот дахь Барилгын политехник коллеж, Налайх зэрэг аймаг хотуудын 7 сургуулиас шалгаран ирсэн 15 суралцагч ур чадвараа сорин өрсөлдлөө. Тэмцээнд оролцогч хүүхдүүд үеийн нөхдөөсөө суралцсан, туршлага хуримтлуулсан үр дүнтэй уралдаан боллоо хэмээсэн юм.

Ур чадварын уралдааны 3 дахь төрөл тогооч мэргэжлээр суралцагчдын дунд болсон юм. Ирээдүйн мэргэжлийн тогооч нарыг бэлтгэн төгсөгдөг мэргэжлийн сургуулиудын дунд ур чадварын уралдаан зохион байгуулснаар суралцагчид орчин үеийн хоол, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний арга технологиос харилцан суралцаж, хоол үйлдвэрлэл үйлчилгээний мэргэжлийн боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх ач холбогдолтой юм. Тогооч мэргэжлийн ур чадварын уралдаанд Сүхбаатар, Дархан–Уул, Төв, Өмнөговь, Хэнтий, Налайх, Улаанбаатар хот дахь Үйлдвэр урлалын политехник коллеж, Шинэ иргэншил, Батлан хамгаалах МСҮТ зэрэг 9 сургуулиас шалгаран ирсэн 13 оролцогч ур чадвар, мэдрэмжээ сорин өрсөлдлөө.



**БАГАНУУР ДҮҮРГИЙН ШИЛДЭГ
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
БАЙГУУЛЛАГА**



ОРОН НУТАГ ХАМТЫН АЖИЛЛАГАА

“Багануур” ХК нь дүүргийн төр захиргаатай байгуулсан “Санамж бичиг”-ийн хэрэгжилтийг хангах, нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 онд дүүрэг орон нутгийн болон хүүхэд залуучууд, гэр бүлд хандсан, мөн уурхайчдаараа дамжуулан дүүргийн иргэдэд нөлөөлөл үзүүлэх олон олон ажлыг хийж ирлээ.

ДҮҮРГИЙН ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙГ ХӨРСӨӨР ХУЧИЖ, ОРЧНЫГ ЭРҮҮЛЖҮҮЛЭХ АЖЛЫГ УУРХАЙЧИД ХИЙЖ ДУУСГАЛАА

Багануур ХК, Багануур дүүргийн төр захиргааны байгууллага хоорондын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд агаар орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах зорилгоор 24.5 га талбайг хамарч байсан хуучин төвлөрсөн хогийн цэгийг дарж булах ажлыг уурхайчид хийж гүйцэтгэн, дүүргийн төр захиргааны байгууллагад хүлээлгэн өглөө.

30 гаран жил болсон, стандартын шаардлага хангахгүй, төвлөрсөн цэг дээр дахин ирж буй хог хаягдлыг асгах талбайгүй хүнд нөхцөлтэй байсныг манай компанийн ТАМАХ-ийн D275 №2110 бульдозер, САТ 988Н №116 ачигч, Cat 777D №193,125,162 дугаартай автосамосвалуудын бригадын хамт олон 25 хоногийн хугацаанд дарж дуусгалаа. Тэд нийт 160 мян.м3 уулын цулын ажил хийж, 30 мян. м3 хөрс зөөж, хур хогийн цэгийг дарсан байна. Ингэхдээ хөрс ачсан овоолгыг буцааж хэлбэршүүлэн байгалийн унаган төрхөнд нь ойртуулж, инженерийн ажлыг гүйцэтгэсэн.



2023 ОНЫ ДҮҮРГИЙН ШИЛДЭГ

“НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА” НОМИНАЦИД ШАЛГАРЛАА



Монгол улсын эрчим хүчний тулгуур уурхай Багануур ХК нь улс орны эрчим хүчний салбарын өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ 2023 онд нийгмийн хариуцлагын хүрээнд дүүрэг орон нутгийн хөгжил, хүүхэд залуус, гэр бүлд чиглэсэн олон ажил зохион байгуулсан. Тухайлбал:

- Агаар орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах зорилгоор 24.5 га талбайг хамарч байсан дүүргийн төвлөрсөн хогийн цэгийг 30 мян.м3 хөрс зөөж дарж булсан. Ингэхдээ хөрс ачсан овоолгыг буцааж хэлбэршүүлэн байгалийн унаган төрхөнд нь ойртуулж, инженерийн ажлыг гүйцэтгэсэн.
- “Бидний дэм малчдад” аян өрнүүлж Багануур дүүргийн мал бүхий иргэдэд 150 ширхэг, хил залгаа 7 сумын малчдад 350

ширхэг тусламжийн багцыг хүргэсэн.

- “Боловсрол цогцолбор” сургуулийн 6–12–р ангийн 43 бүлгийн 1100 гаруй сурагчдад Байгаль орчин, мод тарих арга, хог хаягдлын талаар сургалт зохион байгуулсан
- Дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажилтнуудын өвлийн нормын 629 ширхэг хувцсыг 124.5 сая төгрөгөөр оёулсан.
- Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж 2023 онд 11637 ширхэг мод бут тарьсан.
- “The future of coal baganuur 2023” олон улсын эрдэм шинжилгээний хурал, бизнес хамтын ажиллагааны өдөрлөг зохион байгуулж, эрдэмтэн судлаачдыг Багануур дүүрэгт урьж оролцуулсан
- “Ур чадвар Багануур 2023” улсын уралдааныг Багануур дүүрэгт анх удаа зохион байгуулж тогооч, хүнд машин механизмын оператор, металл боловсруулах суурь машины оператор гэсэн 3 мэргэжлээр Политехник коллежид суралцагчдыг оролцуулсан
- Компанийн 45 жилийн ойн нэрэмжит модон бөмбөгийн УАШТ, “BAGANUUR CUP-2023” U15 насны клубуудын аварга шалгаруулах волейболын тэмцээн, U14 насны цомын аварга шалгаруулах шайбтай хоккейн тэмцээн, сагсан бөмбөгийн U-13, U-11 насны УАШТ зэргийг зохион байгуулж олон зуун тамирчдыг Багануур дүүрэгт урьж оролцуулсан зэрэг ажлуудаараа 2023 оны дүүргийн шилдэг “Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллага”-р шалгарлаа

**БИД СПОРТЫГ ДЭМЖИГЧ
ХАМТ ОЛОН**



УИЦЕ ICE HOCKEY
BAGANUUR CUP-2020
ТЭРГҮҮН Б
700.000

УРЛАГ СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР

“АВЪЯАСЛАГ УУРХАЙЧИД” УРЛАГИЙН НААДАМ

Хоёр жил тутамд зохион байгуулагддаг байсан уурхайчдын урлагийн наадам 2018 оноос хойш 5 жил завсарлаад энэ жил боллоо. 13 дахь удаагийн урлагийн наадам 9 төрлөөр явагдаж, 10 хэсгийн 300 орчим уурхайчин оролцож авьяас билиг, ур чадвараа сорин өрсөлдсөн юм.

“Авьяаслаг уурхайчид” урлагийн наадмын Тэргүүн байранд Д.Нямдалай даргатай Нүүрс бутлан ачих хэсгийн хамт олон шалгарч шилжин явах цом, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнуулсан бол дэд байранд Г.Соронзонболд даргатай Засварын хэсгийн хамт олон, гутгаар байранд П.Энхбат даргатай Уулын 2-р хэсгийн хамт олон тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнууллаа.



“МОДОН БӨМБӨГИЙН УЛСЫН АВАРГА” ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Багануур ХК-ийн 45 жилийн ой, Уурхайчин спорт цогцолборын 15 жилийн ойд зориулан Модон бөмбөгийн “Уурхайчин” клубээс зохион байгуулсан Улсын аварга шалгаруулах тэмцээн 2023.06.16–18-ны өдрүүдэд Багануур дүүрэгт амжилттай болж өндөрлөлөө. Тус тэмцээнд Дархан ШУТИС, Дархан Төмөрлөгийн Үйлдвэр ХК, Багануур ХК, ХААИС, Залуу од спорт клуб, Багануур сувилал ХХК, Багануурын Усан спорт боулингийн төв, Мон-Алтиус дээд сургууль зэрэг 10 байгууллагын 100 гаруй тамирчин оролцож ур чадвараа сорин өрсөлдлөө. Тэдгээрийн дотор модон бөмбөгийн ОУХМ цолтой 10, спортын мастер цолтой 9, спортын дэд мастер цолтой 20 гаруй тамирчин байв



“U15” VOLLEYBALL BAGANUUR CUP 2023



U15 насны клубуудын аварга шалгаруулах “BAGANUUR CUP-2023” тэмцээн 2023.11.06-аас 09-ний өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө.

Сурагчдын 1-р улирлын амралтыг тааруулан зохион байгуулсан тус тэмцээнд Баянхонгор, Өвөрхайнгай, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Дорнод, Сүхбаатар зэрэг аймгуудаас гадна Улаанбаатар хотын сургуулиуд, волейболын клубуудын өсвөрийн эрэгтэй 21, эмэгтэй 20 багийн 500 гаруй тамирчид багш, дасгалжуулагчдын хамт хүрэлцэн ирж хурд хүч, авхаалж самбаа, тэсвэр тэвчээрээ сорин өрсөлдлөө

“U14” ВОЛЕЙБОЛЫН НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН



U14 насны нээлттэй тэмцээн 2023.05.13,14-ний өдрүүдэд Багануур дүүрэгт амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд Дархан-Уул, Говьсүмбэр, Төв зэрэг аймгуудаас гадна Улаанбаатар хотын сургуулиуд, волейболын клубуудын өсвөрийн эрэгтэй 16, эмэгтэй 15 багийн нийт 310 гаруй тамирчид хүрэлцэн ирж ур чадвар, авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдлөө.

“U14” ICE HOCKEY BAGANUUR CUP 2023

U14 насны цомын аварга шалгаруулах шайбтай хоккейн тэмцээн 11-р сарын 9-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн мөсөн талбайд болж өндөрлөлөө. Тэмцээнд:

- Сүхбаатар аймгийн Талын дайчид баг
- Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны Бугант баг
- Дархан-Уул аймгийн Талын шонхорууд баг
- Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Шарын гол баг
- Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Золбоот тамирчид баг
- Орхон-Уул аймгийн Хангарьд баг
- Дархан-Уул аймгийн Хонгор сумын баг
- Улаанбаатар хотын Эй Би баг
- Баянзүрх дүүргийн Отгон од баг
- Багануур ХК-ийн Trippers багийн нийт 170 гаруй өсвөрийн тамирчид оролцож хурд хүч, сорин өрсөлдөв.



ХУЙРНАН ШУУГИГЧ ХҮҮХДИЙН БӨХИЙН БАРИЛДААН

Багануур ХК, MNC телевизийн хамт олонтой хамтран “Хуйрнан шуугигч” хүүхдийн бөхийн барилдааныг Их эзэн Чингис хааны мэндэлсний 861 жилийн ой, Монгол бахархлын өдөр Багануур дүүрэгт зохион байгууллаа.

Монгол бөхийн дэг жаяг, өв соёлыг таниулж өвлүүлэх, хүүхдүүдийг бага наснаас нь үндэсний бөхийн барилдаанаар хичээллэх сонирхлыг төрүүлэх зорилгоор зохион байгуулсан Багануур ХК-ийн 45 жилийн ойн нэрэмжит “Хуйрнан шуугигч” бөхийн барилдаанд ирээдүйд наадмын зүлэг ногоон дэвжээнээ алдар цолоо дуудуулах 220 бяцхан бөх зодоглолоо.

Барилдааны 4-5 насны ангилалд дүүргийн 10 цэцэрлэгийн 160 өхөөрдөм хөөрхөн хүчтэн уран мэхийг уралдуулан барилдав.

Үндэсний бөхийн зодог, шуудгаа өмсөн хоорондоо барилдаж, унаж, уйлж байгаа бяцхан бөхчүүдийг үзсэн бүх л үзэгчид тэднийг хайрлаж, өхөөрдөж, зохион байгуулагчдад талархаж байгаагаа илэрхийлж байв.



БУСАД АРГА ХЭМЖЭЭ

УУРХАЙЧИН СПОРТ ЦОГЦОЛБОРЫН ЗААЛ ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН ВОЛЕЙБОЛЫН ЗОРИУЛАЛТЫН ШАЛТАЙ БОЛЛОО

Итали улсад үйлдвэрлэгдсэн олон улсын стандартад нийцсэн волейболын зориулалтын шалыг Монгол улсад волейболын спортыг хөгжүүлэхийг дэмждэг Бүгд Найрамдах Солонгос улсын иргэд бэлэг болгон өгсөн юм.

Волейболын зориулалтын шалтай болсноор “Уурхайчин” клубын өсвөрийн тамирчид болон Багануур ХК-ийн шигшээ багийн тамирчдын амжилт улам ахина гэдэгт итгэл дүүрэн байна.



ХҮНДЭЛЬЕ-СУРАЛЦЬЯ-ХУВААЛЦЬЯ АРГА ХЭМЖЭЭ

Сүүлийн 3 жилд Багануурын уурхайн анхдагч ажилтнуудын нэгэн бүтэн үе гавьяаны амралтаа гарч, шинэ залуу ажилтнууд хүч түрэн орж ирж байна. 2022-2023 онд Багануур ХК-нд шинээр ажилд орсон 89 шинэхэн уурхайчинд зориулсан ХҮНДЭЛЬЕ-СУРАЛЦЬЯ-ХУВААЛЦЬЯ сэдэвт чиглүүлэх өдөрлөг боллоо.

Энэхүү өдөрлөг нь шинэ ажилтнуудад компанийн эрхэм зорилго, алсын хараа, үүсэл хөгжил, үйл ажиллагааны чиглэл, бүтэц орон тоо, дүрэм журмыг танилцуулж уурхайчид гэх том багийн нэг гишүүн болж, амжилттай ажиллахад нь чиглүүлэх зорилготой.



СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ ОЛГОВ

Ахмадын баярын арга хэмжээн дээр үеийн уурхайчдын залгамж халаа болсон уурхайчид болон ирээдүйн уурхайн эзэд болох оюутан залуусдаа сургалтын тэтгэлэг олгохоор шийдвэрлэн, батламжийг гардуулж баярт мөчийг ахмад уурхайчидтайгаа хуваалцсан юм.

2023-2024 оны хичээлийн жилийн сургалтын тэтгэлэг олгох сонгон шалгаруулалтад Багануур ХК-ийн 4 ажилтан, ШУТИС-ийн 1 оюутан тэнцсэн.



ӨРХ ГЭР АМЖИЛТИЙН ҮНДЭС ГЭР БҮЛИЙН ӨДӨРЛӨГ



5-р сарын 15-ны өдөр бол олон улсын гэр бүлийн өдөр. “Багануур” ХК 2023 онд Багануур дүүргийн Өргөө соёлын ордонд “Өрх гэр-Амжилтын үндэс” сэдэвт өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш, доктор, дэд профессор, менежментийн зөвлөх З.Алтанчимэг өрхийн санхүү, орлого зарлагын менежмент сэдвээр сонирхолтой лекц уншлаа. Мөн Багануур –Сувилал ХХК-ийн урилгаар Улсын 1-р төв эмнэлгийн хоол зүйч Э.Санчир, Б.Уянга нар хүрэлцэн ирж “Эрүүл амьдралын хэвшил”, “Эрүүл хооллолт” сэдвээр маш сонирхолтой мэдээлэл өглөө. Өдөрлөгийн үеэр “Багануур-Сувилал” ХХК-ийн эрүүл зохистой хоолны амталгаат үзэсгэлэн, эрүүл мэндийн үзлэг оношилгоо – зөвлөгөө, “Монос” ХХК, “Тимус фарма” ХХК-ийн эрүүл мэндийн оношилгоо, зөвлөгөө, бүтээгдэхүүн танилцуулга, Мобиком-Багануур салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг нэг дор төвлөрүүлсэн нь ажилтнуудын гэр бүлүүдийн талархлыг хүлээсэн арга хэмжээ болов. Мөн компанийн эцэг эхийн зөвлөлөөс хүүхдийг аюул ослоос урьдчилан сэргийлэх санамж анхааруулга тараалаа.

ЭЛЧИН САЙДУУД “БАГАНУУР ХК”-Д АЙЛЧЛАВ



12 дугаар сарын 25-ны өдөр Элчин сайд М.Игавахара “Багануур” Хувьцаат Компани үүсгэн байгуулагдсаны 45 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнд оролцож, олон жил Монгол Улсын эдийн засгийг тэтгэж, нүүрс олборлолтыг тасралтгүй үргэлжлүүлж ирсэн уурхайчдад баяр хүргэлээ.



Мөн Бүгд Найрамдах Чех улсын Элчин сайд ноён Ян Вытопил Багануур ХК-д 2023 оны 04 дүгээр сард зочлон хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

АУДИТЫН ТАЙЛАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024-03-15 № 07/729

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Багануур ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил нь бидний тогтоосон 1,610.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант оны эцэст 989.3 сая төгрөгийн өр төлбөр, 3,005.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй ба 535.8 сая төгрөгийн өр төлбөр, 1,550.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл насжилт өндөртэй буюу авлага, өглөгийг хугацаанд нь барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй;
- Тус байгууллагад бүртгэлтэй 8 газар эзэмших эрхийн үнэлгээг хийгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй;
- Санхүүгийн тайланд тусгагдсан 1,167.0 сая төгрөгийн нөөц өр төлбөртэй холбоотой баримт, тооцооллыг аудитад ирүүлээгүй тул тус үлдэгдлийг үнэн зөв эсэхийг баталгаажуулах боломжгүй зэрэг зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.6, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант жилд хөрс хуулалт, нүүрс тээврийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай томоохон машин, тоног төхөөрөмжийг шинээр худалдан авсан, мөн сүүлийн жилүүдэд хийгдээгүй байсан технологийн авто машинуудын хөдөлгүүр болон томоохон их засваруудыг хийж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 34,893.2 сая төгрөг зарцуулсан байна.

Багануур ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 210,507.5 сая төгрөгийн 62 алдаа, зөрчил илэрснийг ажлын хэсэг томилон шуурхай арга хэмжээ авч ажиллан 49 алдаа зөрчлийг залруулан ажилласан байна.

Аудитын гол асуудал

Багануур ХК нь 242,920.5 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийн үлдэгдэлтэй, өр төлбөрийг гэрээнд заасан хугацаанд барагдуулаагүйгээс худалдан авах ажиллагаа зохион байгуулахад хүндрэл үүсч, оролцогч компаниудын тоо буурах, гэрээний гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй болох, урт хугацаат зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй зэрэг сөрөг үр дагавар үүсэж байгаа нь Эрчим хүчний зохицуулах хорооноос нүүрсний борлуулалтын үнэ тарифыг өртгөөс нь бага үнээр тогтоож ирсэнтэй холбоотой ба үүнээс компанийн ашигт ажиллагаа болон тасралтгүй үйл ажиллагаанд эрсдэл үүсэхээр байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 19 зорилтын хүрээнд 47 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 91.6 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



Багануур ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,982,323,532.05	2,417,234,743.19
1.1.2	Дансны авлага	10,010,013,641.16	4,547,818,310.13
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	739,531,557.44	27,915,379.57
1.1.4	Бусад авлага	74,240,000.00	3,646,675,927.60
1.1.6	Бараа материал	45,001,906,854.70	49,354,185,876.94
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10,839,246,771.63	-
	Эргэлтийн хөрөнгийн дүн	70,647,262,356.98	63,603,789,147.13
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	151,858,946,967.51	169,952,205,306.91
1.2.2	Биет бус хөрөнгө	4,358,225,684.60	4,600,596,254.79
1.2.3	Уул уурхайн хөрөнгө /Хөрс хуулалт/	27,209,712,833.10	25,563,066,622.70
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	999,767,331.34	999,767,331.34
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	764,393,387.00	764,393,387.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		3,609,958,909.70
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	185,191,046,203.55	201,880,028,902.74
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	255,838,308,560.53	265,483,818,049.87
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	52,405,529,509.13	60,720,143,664.51
2.1.1.2	Цалингийн өглөг	2,521,958,781.00	2,616,642,414.86
2.1.1.3	Татварын өр	48,087,404,572.38	53,284,067,637.36
2.1.1.4	НДШ-ийн өглөг	12,179,131,636.82	8,287,925,455.68
2.1.1.5	Богино хугацаат зээл	46,716,839,284.27	3,766,628,727.10
2.1.1.6	Хүүний өглөг	2,579,831,249.31	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	12,968,712.50	12,968,712.50
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	1,640,742,814.39
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	431,594,370.84	50,788,049.31
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	164,935,258,116.25	130,379,907,475.71
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	47,395,869,334.18	102,185,389,999.85
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	1,167,266,443.09	1,167,266,443.09
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	8,103,541,421.55	9,187,960,486.21
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	56,666,677,198.82	112,540,616,929.15
2.2	Өр төлбөрийн нийт дүн	221,601,935,315.07	242,920,524,404.86
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	- хувийн	524,359,000.00	524,359,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	60,685,388,076.98	60,685,388,076.98
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(28,546,450,831.52)	(40,219,530,431.97)
2.3.11	Эздийн өмчийн дүн	34,236,373,245.46	22,563,293,645.01
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	255,838,308,560.53	265,483,818,049.87

Багануур ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	160,262,944,907.10	210,096,473,086.23
2	Борлуулалтын өртөг	163,002,692,433.64	204,142,122,501.47
3	Нийт ашиг(алдагдал)	(2,739,747,526.54)	5,954,350,584.76
4	Түрээсийн орлого	20,563,400.00	34,070,947.73
5	Хүүгийн орлого	-	13,894,581.72
6	Ногдол ашгийн орлого	-	12,863,696.52
8	Бусад орлого	782,792,383.66	386,737,611.97
9	Борлуулалт, маркетингийн зардал	567,136,179.19	647,053,456.31
10	Ерөнхий ба удирдлагын зардал	21,506,033,983.12	13,265,655,474.83
11	Санхүүгийн зардал	3,065,094,742.48	2,685,116,635.38
12	Бусад зардал	5,600,353,774.58	885,872,898.97
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(984,174,801.56)	1,566,308,195.77
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(33,659,185,223.81)	(9,515,472,847.02)
19	Орлогын татварын зардал	25,020,000.01	1,389,458.17
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(33,684,205,223.82)	(9,516,862,305.19)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(33,684,205,223.82)	(9,516,862,305.19)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	(33,684,205,223.82)	(9,516,862,305.19)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Багануур ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Тусгай зориулалтын нөөцийн сан	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	8,482,120,309.04	7,294,912,713.63	78,559,857,099.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(8,482,120,309.04)		(8,482,120,309.04)
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	7,294,912,713.63	70,077,736,790.61
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				(33,684,205,223.82)	(33,684,205,223.82)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт				(2,157,158,321.33)	(2,157,158,321.33)
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(28,546,450,831.52)	34,236,373,245.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(28,546,450,831.52)	34,236,373,245.46
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(9,516,862,305.19)	(9,516,862,305.19)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт				(2,156,217,295.26)	(2,156,217,295.26)
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(40,219,530,431.97)	22,563,293,645.01

Багануур ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	161,237,556,096.93	211,205,772,188.83
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	160,957,619,734.73	210,909,990,145.16
1.1.4	Буцаан авсан албан татвар	223,252,668.73	269,520,748.42
1.1.6	Бусад мөнгөн орлого	56,683,693.47	26,261,295.25
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	144,019,366,656.87	201,263,308,232.25
1.2.1	Ажиллагчдад төлсөн	46,049,400,143.33	41,605,342,476.92
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,821,333,442.71	17,278,689,407.40
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	32,105,961,299.76	77,268,930,989.11
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	39,813,145,427.81	50,828,908,506.36
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	132,547,301.21	1,044,881,385.10
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	14,907,385,790.66	10,856,724,554.40
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,189,593,251.39	2,379,830,912.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,218,189,440.06	9,942,463,956.58
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	13,801,304.98
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		13,801,304.98
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,294,679,711.54	25,517,179,533.48
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,250,000,664.54	25,406,785,735.48
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	44,679,047.00	110,393,798.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,294,679,711.54)	(25,503,378,228.50)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	31,273,553,657.00	55,004,840,525.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	31,273,553,657.00	55,004,840,525.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	31,268,648,788.97	41,008,796,217.77
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	31,268,648,788.97	41,008,796,217.77
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,904,868.03	13,996,044,307.23
4	Валютын ханшийн зөрүү	3,866,126.79	(218,824.17)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,932,280,723.34	(1,565,088,788.86)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,050,042,808.71	3,982,323,532.05
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,982,323,532.05	2,417,234,743.19

ХОЛБОО БАРИХ:

Шуудангийн хайрцаг: 12150 Улаанбаатар хот, Багануур дүүрэг, ш/х-554

Хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг 3 дугаар хороо, (Үйлдвэрийн хэсэг)

Утас: (976) 70210791

Бичиг хэргийн эрхлэгч: (976) 70210114

Үйлдвэр борлуулалтын алба: (976) 70210414, (976) 70213145

Факс: (976) 70213130

Цахим шуудан: bjsc@baganuurmine.mn

Цахим хуудас: www.baganuurmine.mn